



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эмнэхүй ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/098/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор:  
Г.Нандинжаргал  
Утас: 7000-7734 Цахим хаяг: [nandinjargalg@audit.gov.mn](mailto:nandinjargalg@audit.gov.mn)  
Санхүү, аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр  
Утас: 11315558 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)  
Аудитын менежер: Я.Алтанцэцэг  
Утас: 11315558 Цахим хаяг: [altantsetseg.ya@audit.mn](mailto:altantsetseg.ya@audit.mn)  
Их наяд аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Х.Ариунзул  
Утас: 99077062 Цахим хаяг: [ikhayadaudit@gmail.com](mailto:ikhayadaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 835  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ  
ДҮҮРГИЙН ЭМНЭХҮЙ ӨЭМТ-ИЙН  
ДАРГА Б.НОМИНЧУЛУУН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эмнэхүй ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эмнэхүй ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 27.1 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эмнэхүй ӨЭМТ нь 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 698.7 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

### **Аудитын гол асуудал**

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эмнэхүй ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/145 захирамжаар 95.2 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 98.0 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эмнэхүй ӨЭМТ-ийн даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар бүтэц орон тоог 14 ажилтнаар баталж, 13 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	448,854.69	8,716,928.30
Дансны авлага	86,738,408.40	7,442,354.50
Бараа материал	53,838,817.35	57,184,989.98
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>141,026,080.44</b>	<b>73,344,272.78</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
Үндсэн хөрөнгө	104,511,939.96	79,580,270.91
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>104,511,939.96</b>	<b>79,580,270.91</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>245,538,020.40</b>	<b>152,924,543.69</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
<b>Өр төлбөр</b>	-	-
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	-	-
Дансны өглөг	-	-
Урьдчилж орсон орлого	66,828,662.73	66,828,662.73
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>66,828,662.73</b>	<b>131,076,654.73</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>66,828,662.73</b>	<b>131,076,654.73</b>
<b>Эзэмшигчдийн өмч</b>	-	-
Төрийн	16,869,185.00	16,869,185.00
Хувийн	-	-
Хуримтлагдсан ашиг	161,840,172.67	69,226,695.96
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>178,709,357.67</b>	<b>86,095,880.96</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>245,538,020.40</b>	<b>152,924,543.69</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>Борлуулалтын орлогын дүн</b>	<b>6,944,500.00</b>	-
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>6,944,500.00</b>	-
Санхүүжилтийн орлого	749,644,504.43	698,693,853.60
Хүүний орлого	283,854.73	398,492.61
Бусад орлого	20,483,572.40	19,590,180.37
Ерөнхий ба удирдлагын зардал	687,662,541.36	811,296,003.29
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>89,693,890.20</b>	<b>(92,613,476.71)</b>
Орлогын татварын зардал	-	-
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>89,693,890.20</b>	<b>(92,613,476.71)</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>89,693,890.20</b>	<b>(92,613,476.71)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>Мөнгөн орлогын дүн</b>	-	-
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	702,395,267.76	793,045,920.13
<b>Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн</b>	<b>702,395,267.76</b>	<b>793,045,920.13</b>
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	-	-
Ажиллагчдад төлсөн	484,458,104.00	621,371,775.82
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	84,583,839.33	-
Бараа материал худалдан авахад төлсөн	89,292,918.88	114,728,296.44
Ашиглалтын зардалд төлсөн	-	1,200,000.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,975,640.00	1,941,000.00
Бусад мөнгөн зарлага	29,531,645.48	45,536,774.26
<b>Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн</b>	<b>690,842,147.69</b>	<b>784,777,846.52</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>11,553,120.07</b>	<b>8,268,073.61</b>
<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ дүн</b>	-	-
<b>Мөнгөн орлогын дүн</b>	-	-
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн</b>	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	4,565,000.00	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,572,500.00	-
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн</b>	<b>11,137,500.00</b>	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(11,137,500.00)</b>	-
<b>Санхүүгийн мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
<b>Мөнгөн орлогын дүн</b>	-	-
<b>Санхүүгийн мөнгөн орлогын дүн</b>	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	-	-
<b>Санхүүгийн мөнгөн зарлагын дүн</b>	-	-
<b>Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>415,620.07</b>	<b>8,268,073.61</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>33,234.62</b>	<b>448,854.69</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>448,854.69</b>	<b>8,716,928.30</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
<b>2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>16,869,185.00</b>	-	-	<b>72,146,282.47</b>	<b>89,015,467.47</b>
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Өмчит гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Тайлант үеийн ашиг, алдагдал	-	-	-	89,693,890.20	<b>89,693,890.20</b>
<b>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>16,869,185.00</b>	-	-	<b>161,840,172.67</b>	<b>178,709,357.67</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>16,869,185.00</b>	-	-	<b>161,840,172.67</b>	<b>178,709,357.67</b>
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Өмчит гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Тайлант үеийн ашиг, алдагдал	-	-	-	(92,613,476.71)	<b>(92,613,476.71)</b>
<b>2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>16,869,185.00</b>	-	-	<b>69,226,695.96</b>	<b>86,095,880.96</b>

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 234,968.0 мянган төгрөгийн 7 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Авлагыг буруу бүртгэж өмнөх оны үлдэгдэлийг бууруулаагүй данс буруу бүртгэсэн байна.	1	86,569.4			1	86,569.4	1	86,569.4				
2	Санхүүжилтийн орлогын бичилтийг буруу бүртгэж дутуу тайлагнасан ба ХЧТАТ-ийг орлогоор бүртгэсэн байна.	1	54,952.2			1	54,952.2	1	54,952.2				
3	Цалингийн зардал, ХХОАТ, НДШ, гарт олгох цалингийн бичилтийг буруу бүртгэж тайлагнасан байна.	1	8,752.3			1	8,752.3	1	8,752.3				
4	Үнэ төлбөргүй ирсэн үндсэн хөрөнгө бүртгээгүй байна.	1	3,250.0	1	3,250.0			1	3,250.0				
5	Элэгдлийн зардлыг дутуу байгуулсан байна.	1	28,731.4			1	28,731.4	1	28,731.4				
6	Зардлыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй өглөгийг хасах үлдэгдэлтэй илэрхийлсэн байна.	1	51,409.8			1	51,409.8	1	51,409.8				
7	Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны А/58 дугаар тушаалаар үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн төгрөгийн барааг бүртгэж аваагүй байна.	1	1,302.9	1	1,302.9			1	1,302.9				
	<b>Дүн</b>	<b>7</b>	<b>234,968.0</b>	<b>2</b>	<b>4,552.9</b>	<b>5</b>	<b>230,415.1</b>	<b>7</b>	<b>234,968.0</b>				

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

**3.2** Аудитаар нийт 27,056.5 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>2</sup> илэрсэнд 3,476.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 17,951.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 5,628.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зэрэгцэн ажил гүйцэтгэдэг нягтлан бодогчид сар бүр хоол, унааны мөнгө болон удаан жилийн нэмэгдэл тооцож олгосон байна.	1	3,476.6	1	3,476.6				
Тус өрх нь дарга, нөхөрлөлийн гишүүдийн хурлаар 2024 оны ашиг хуваарилах санал оруулж нөхөрлөлийн гишүүдэд 17,951.0 мянган төгрөгийг хуваан өгсөн байна.	1	17,951.0			1	17,951.0		
Мөнгөн хөрөнгийн зарлагыг анхан шатны баримттай тулган шалгахад и-баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэсэн байна.	1	5,628.9					1	5,628.9
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 18 нэр төрлийн (23,953.8 мянган төгрөгийн) хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг холбогдох байгууллагат хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>27,056.5</b>	<b>1</b>	<b>3,476.6</b>	<b>1</b>	<b>17,951.0</b>	<b>2</b>	<b>5,628.9</b>

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**3.3** Аудитаар нийцлийн асуудлаар нийт 98,747.8 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Тус ӨЭМТ нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх 3-р улирлын 82,991.6 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	82,991.6					1	82,991.6
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>82,991.6</b>					<b>1</b>	<b>82,991.6</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Санхүүгийн тайлан болон ажлын баримт материалыг цаг тухайд хүргүүлээгүй байна.	1	-					1	-
Тус өрх нь бүтэц орон тоог батлахдаа хавсран ажлыг оруулж бүртгэж батлаагүй байна.	1	-					1	-
Тус өрх нь даргын тушаал шийдвэргүй 15,756.2 мянган төгрөгийн урамшуулал, ур чадвар, үр дүнгийн нэмэгдэл олгосон байна.	1	15,756.2					1	15,756.2
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>15,756.2</b>					<b>3</b>	<b>15,756.2</b>
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>98,747.8</b>					<b>4</b>	<b>98,747.8</b>